



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН “БОР-ӨНДӨР” ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 5/138


Бор-Өндөр

**Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний
үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгох тухай**

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Боловсролын үнэлгээний төвийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/321 тоот албан бичиг, Боловсролын ерөнхий газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1649 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн хөдөлмөрийн үнэлгээг бодитой тооцож, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлж, гүйцэтгэлийн үнэлгээний 1-4 индексээр үнэлүүлж дүгнүүлсэн багш нарт хавсралт ёсоор 4-р улирлын мөнгөн урамшууллыг олгосугай.

2. Мөнгөн урамшууллыг зохих журмын дагуу тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ц.ГАНХҮҮ

